



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/65

Булган сум

“Эхийн буян” ардын чуулгын зочид төлөөлөгчдийн
байр, хоол бусад зардалд хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Алтаргана XV наадмын хүрээнд Буриад улсын Закаменск районы “Эхийн буян” ардын чуулгын зочид төлөөлөгчдийн байр, хоол бусад зардалд 5,150,000 (таван сая нэг зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.


2. Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Дэлхийн Алтаргана 2024” төлөвлөгдсөн хөрөнгөөс 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Санхүү, төрийн саңгийн хэлтэс (Д.Батцогт)-т, 2,650,000 (хоёр сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д тус тус санхүүжүүлэхийг зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
02-дугаар сарын 08-ны өдрийн А.69... дугаар
захирамжийн хавсралт



“АЛТАРГАНА 2024” ОЛОН УЛСЫН НААДМЫН ХҮРЭЭНД ХҮРЭЛЦЭН ИРСЭН
ЗОЧИД ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ.

Д/д	Шаардагдах зардал	Хүний тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1.Байр зардал				
1.	Буудал /1 хоног/	20	75,000	1,500,000
	Нийт			1,500,000
2.Бусад зардал				
1.	Шатахуун	-	1,150,000	1,150,000
2	Хоол / 2 хоног/	20	125,000	2,500,000
	Нийт			3,650,000
	Нийт дүн			5,150,000